

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2024/10/НА-СТА-ОНА

ЗУУНМОД ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ ОНӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗТХЯ	Зам Тээвэр Хөгжлийн Яам
ЗТХТ	Зам тээвэр хөгжлийн төв



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 01/2025
танай _____-ны № _____-г

Г **ЗУУНМОД ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ** Г
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Г.ЖАРГАЛЦЭЦЭГ ТАНАА

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ нь тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний өртгийг дутуу тооцоолсон, 10,685.3 мянган төгрөгийг нэхэмжлэхгүйгээр хувь хүний данс руу шилжүүлэн уг дүнгээр Монсульт ШТС-аас төлбөрийн баримт авсан, өглөгийг барагдуулалгүй харилцах дансны үлдэгдэл 22,369.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ нь Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор 322,297.9 мянган төгрөгийн 20 бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэн Зуунмод сумын орчны тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд батлагдсан орлогын бүрдүүлэлт 16 хувиар тасарч, Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын удирдах зөвлөлийн тогтоолоор Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын ажилчдын үндсэн цалинг 2023 оны 9 дүгээр сарын 01-нээс эхлэн 30 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор зардлыг 5,4 хувиар хэтрүүлэн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,610,917.13	47,475,123.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,580,355.13	22,369,504.92
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,580,355.13	22,369,504.92
31210	Төгрөг	2,580,355.13	22,369,504.92
31213	Арилжааны банк дахь харилцах	2,580,355.13	22,369,504.92
33	АВЛАГА	608,000.00	1,252,627.26
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	1,996.57
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0	555,830.69
33500	Бусад авлага	608,000.00	694,800.00
33510	Байгууллагаас авах авлага	608,000.00	694,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,422,562.00	23,852,991.19
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	7,298,298.00	9,501,406.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,688,264.00	7,045,212.45
35400	Хангамжийн материал	2,436,000.00	7,306,372.74
35410	Бичиг хэргийн материал	0	32,727.29
35470	Бусад хангамжийн материал	2,436,000.00	7,273,645.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	279,928,119.00	245,786,413.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	279,928,119.00	245,786,413.94
39200	Биет хөрөнгө	279,928,119.00	245,786,413.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	209,741,395.00	209,741,395.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-183,478.00	-16,925,887.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63,481,000.00	63,481,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-139,136.00	-12,835,336.44
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,336,190.00	6,336,190.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,701,199.00	-5,869,293.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,605,000.00	4,605,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,211,653.00	-2,746,652.97
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	300,539,036.13	293,261,537.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	295,172,001.90	304,919,615.66
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	295,172,001.90	304,919,615.66
41300	Өглөг	295,172,001.90	304,919,615.66
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	22,816.00	0
41360	Бусад өглөг	295,149,185.90	304,919,615.66
41361	Байгууллагад төлөх өглөг	278,222,395.00	273,222,395.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	5,332,588.90	28,652,620.66
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	2,165,314.00	0
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	9,428,888.00	3,044,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,367,034.23	-11,658,078.35
51	Засгийн газрын хувь оролцоо	5,367,034.23	-11,658,078.35
51200	Хуримтлагдсан үр дүн	5,367,034.23	-11,658,078.35
51210	Өмнөх үеийн үр дүн	0	5,903,737.51
51220	Тайлант үеийн үр дүн	5,367,034.23	-17,561,815.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	300,539,036.13	293,261,537.31

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	51,052,942.73	338,740,529.46
2	Борлуулалтын өртөг	40,864,058.88	104,707,258.81
3	Нийт ашиг (алдагдал)	10,188,883.85	234,033,270.65
8	Бусад орлого	178,853,844.55	38,217,000.00
8	Бусад орлого (Татвар ногдох орлого)	178,853,844.55	38,217,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	779,373.00	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	182,299,984.18	288,523,539.51

12	Бусад зардал		1,288,547.00
300	Бусад зардал (татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал)		1,288,547.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,963,371.22	(17,561,815.86)
19	Орлогын татварын зардал	596,337.12	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	5,367,034.10	(17,561,815.86)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,367,034.10	(17,561,815.86)
24	Орлогын нийт дүн	5,367,034.10	(17,561,815.86)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	-	5,367,034.09	5,367,034.09
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		536,703.42	536,703.42
3	Залруулсан үлдэгдэл	-	5,903,737.51	5,903,737.51
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(17,561,815.86)	(17,561,815.86)
5	Бусад дэлгэрэнгүй орлого			-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-		-
7	Зарласан ногдол ашиг			-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
9	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	-	(11,658,078.35)	(11,658,078.35)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	233,345,470.00	408,037,513.11
111	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	56,453,270.00	366,049,213.11
115	Татаас, санхүүжилтийн орлого	170,050,800.00	-
116	Бусад мөнгөн орлого	6,841,400.00	41,988,300.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	221,836,114.87	388,248,363.32
121	Ажиллагчдад төлсөн	92,917,361.37	145,947,341.93
122	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	24,855,317.04	44,924,784.72
123	Бараа материал худалдан авахад төлсөн	75,880,190.00	158,057,752.50
124	Ашиглалтын зардалд төлсөн	601,130.61	1,243,530.65
125	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,915,560.00	13,395,513.50
127	Татварын байгууллагад төлсөн	3,212,632.56	19,034,044.67
128	Даатгалын төлбөрт төлсөн	387,175.00	280,000.00
129	Бусад мөнгөн зарлага	12,066,748.29	5,365,395.35
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,509,355.13	19,789,149.79
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,929,000.00	-
221	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,929,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,929,000.00)	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,580,355.13	19,789,149.79
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,580,355.13
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,580,355.13	22,369,504.92

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

дд	Үзүүлэлт	2023 он			
1	Орлого	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувь
1.1	Хөрөнгө оруулалтын санхүүжилт	299,881.70	289,463.23	(10,418.47)	97%
1.2	Сумын ИХ-ын бүтээн байгуулалтын ажил	10,000.00	5,000.00	(5,000.00)	50%
1.3	Төв гудамжны ногоон байгууламжийн тохижилтын ажил	19,997.45	19,650.21	(347.24)	98%
1.4	Борлуулалтын орлого	60,935.97	61,566.08	630.11	101%
1.5	Сургалт, зөвөлгөө	1,000.00	1,194.00	194.00	119%
1.6	Ногоон байгууламжийн усалгаа	600.00	550.00	(50.00)	92%
1.7	Бусад орлого /тайралт, арчилгаа тордолгоо/	350.00	110.00	(240.00)	31%
1.8	Хандив тусламж	0.00	5,000.00	-	
1.9	Нэмэлт санхүүжилт Зуунмод ЗДТГ-аас	0.00	30,000.00	-	
	Нийт орлого	392,765.12	412,533.51	-15,231.60	105%
2.1	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зардал				
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны санхүүжилтээр хийгдэх ажлын материалын зардал	90,504.37	90,504.37	-	100%
	Сумын ИХ-ын бүтээн байгуулалтын ажлын зардал	8,819.60	8,819.60	-	100%
	Төв гудамжны ногоон байгууламжийн тохижилтын ажлын зардал	17,732.85	17,732.85	-	100%
	Хөрөнгө оруулалтын зардлын дүн	117,056.82	117,056.82	-	100%
2.2	Үндсэн үйл ажиллагааны урсгал зардал				
	Цалин хөлс	178,803.88	180,663.43	(1,859.55)	101%
	Ажил олгогчоос төлөх НДШ	24,512.95	22,281.92	2,231.03	91%
	Татварын зардал	5,332.59	5,332.59	-	100%
2.2.2	Ашиглалтын зардал				
	Гэрэл цахилгаан /квт-аар/	1,440.00	494.37	945.63	34%
	Дулаан, цэвэр бохир ус	1,614.99	1,360.00	254.99	84%
	Шуудан холбоо, интернет	966.00	662.50	303.51	69%
	Программ хангамж	180.00	200.00	(20.00)	111%
	Байрны түрээс	6,000.00	6,000.00	-	100%
2.2.3	Хангамж бараа материал				
	Шатахуун шатах тослох материал	20,169.56	6,456.93	13,712.63	32%
	Бичиг хэргийн зардал	2,347.00	1,097.64	1,249.36	47%
	Цэвэрлэгээ, хангамжийн материал	1,516.40	2,314.42	(798.02)	153%
	Хөдөлмөр хамгааллын зардал	6,795.00	3,747.00	3,048.00	55%
2.2.4	Эд хогшил урсгал засварын зардал				
	Урсгал засварын зардал	2,082.71	16,612.21	(14,529.50)	798%
	Багаж техник хэрэгсэл	10,976.00	2,154.90	8,821.10	20%
	Сэлбэг засварын зардал	5,000.00	3,915.05	1,084.95	78%
	Элэгдлийн зардал	0.00	34,141.70	(34,141.70)	
2.2.5	Томилолт	1,000.00	344.00	656.00	34%
2.2.6	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	3,504.62	6,549.80	(3,045.18)	187%
2.2.7	Татвар төлбөр хураамжийн зардал				
	АМӨЯХТатвар	115.00	147.60	(32.60)	128%
	Авто машины агаарын бохирдол	16.50	19.00	(2.50)	115%
	Албан журмын даатгал	299.40	-	299.40	0%
	Замын хураамж	37.00	30.00	7.00	81%
	Автомашинны оношилгоо	88.00	63.00	25.00	72%
	Банкны хураамж	200.00	117.30	82.70	59%
	Аудитын төлбөр	600.00	784.00	(184.00)	131%
	Бусад төлбөр хураамж	900.00	125.00	775.00	14%
2.2.8	Ажилчдын даатгал (Гэнэтийн осол)	329.00	280.00	49.00	85%
2.2.9	Бусад зардал	1,000.00	1,115.72	(115.72)	112%
	Үндсэн үйл ажиллагааны урсгал зардлын дүн	275,826.60	297,010.07	(21,183.46)	108%
	Нийт зардал	392,883.42	414,066.88	(21,183.46)	105%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

“Зуунмод цэцэрлэгжүүлэлт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь Төв аймгийн Зуунмод Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 103 дугаар тогтоол, Зуунмод сумын Засаг дарга 2021 оны 404 дүгээр захирамжаар байгуулагдсан Зуунмод сумын хэмжээнд ногоон байгууламжийг хариуцан ажиллах Зуунмод сумын ТТЗ-ын харьяа байгууллага юм.

3.2 Компани/ ОНӨААТҮГ -ын гадаад, дотоод орчин

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үндсэн зорилт нь Зуунмод сумын ногоон байгууламжийн бүрэн бүтэн байдал, нийтийн эзэмшлийн газрыг зүлэгжүүлэх, цэцгийн ургамлын үрслэг ургуулах, шилжүүлэн суулгах, цэцэрлэгжүүлэх, мод үржүүлэг, мод бутны ургалт, хашаа хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,277.5 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,580.36	22,369.50	19,789.15
АВЛАГА	608.00	1,252.63	644.63
БАРАА МАТЕРИАЛ	17,422.56	23,852.99	6,430.43
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	279,928.12	245,786.4	(34,141.70)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	300,539.04	293,261.54	(7,277.5)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	295,172.00	304,919.62	9,747.61
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,367.03	(11,658.08)	(17,025.11)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	300,539.04	293,261.54	(7,277.50)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос өсөж, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс буурсан үзүүлэлттэй байна.Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс арилжааны банк дах харилцах 19,789.1 мянган төгрөгөөр өссөн байна.
- Авлага дансны хувьд ажиллагсадтай холбогдсон авлага 2.0 мянган төгрөг, төсөвт байгууллагад худалдсан мод, цэцгийн ваарын үнэ төлөгдөөгүйгээс байгууллагаас авах авлага 644.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.
- Бараа материал дансны хувьд бэлэн бүтээгдэхүүн 643.1 мянган төгрөгөөр буурч, дуусаагүй үйлдвэрлэл 2,203.1 мянган төгрөг, хангамжийн материал 4,870.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
- Үндсэн хөрөнгө данс 34,141.7 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн дүнгээр буурсантай холбоотой байна.
- Өр төлбөр дансны хувьд 9,747.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсөв хүрэлцээгүйгээс НӨАТ-ийн өглөг үүссэнтэй холбоотой байна.
- Эздийн өмч дансны үлдэгдэл -11,658.1 мянган төгрөг болж -17,025.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын захирал Зуунмод сумын Засаг даргатай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний нэгдүгээр хавсралтаар 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 392,883.4 мянган төгрөгөөр, нийт зардлыг 392,883.4 мянган төгрөгөөр алдагдалгүй ажиллахаар тогтоосон байна.

Нийт орлогын гүйцэтгэл 412,533.51 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 15,231.6 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар давж биелсэн нь хандив тусламж, Зуунмод сумын ЗДТГ-аас олгосон нэмэлт санхүүжилтийн орлого нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 414,066.88 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 21,183.46 мянган төгрөгөөр илүү буюу 105.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ийн 2023 оны санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 015 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 233,345.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,327.5 мянган төгрөгөөр тогтоосны 75 хувиар гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2,495.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ нь байгууллагад бүртгэлтэй 2917ТӨА улсын дугаарыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу цэнхэр дэвсгэрээр сольсон байна.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ нь тайлант онд төсвийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 147 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 9 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 48,420.7 мянган төгрөгийн 12 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 327,207.1 мянган төгрөгийн 40 гүйлгээний мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ийн 2023 оны эхний хагас жилийн баримтад завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмжийг өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын захирлын 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 01/147 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	934.5	1	934.5	100
Албан шаардлага					
Зөвлөмж	3	42,512.7	3	42,512.7	100
Нийт дүн	4	413,652.0	4	413,652.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар алдаа¹ илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

5.2 Албан шаардлага

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ гаргасан.

Илрүүлэлт: Тайлант онд 10,685.3 мянган төгрөгийг нэхэмжлэхгүйгээр хувь хүний данс руу шилжүүлэн уг дүнгээр Монсуль ШТС-аас төлбөрийн баримт авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэг хүлээнэ" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан 4.2.1.11-д "Хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Өр төлбөрийг барагдуулаагүй.

Илрүүлэлт: тайлант онд үүссэн өглөгийг барагдуулалгүй харилцах дансны үлдэгдэл 22,369.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэг хүлээнэ" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан 4.2.1.11-д "Хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бүтээгдэхүүний өртгийг тооцохдоо худалдаж авсан үнээр тооцоолсон ба бүтээгдэхүүнийг олж бэлтгэхтэй холбогдон гарсан зардлыг нэмж тооцоолоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын өртгийг тооцоолохдоо НБББББ-ын бараа материалын бүртгэлийн бодлогод заасны дагуу үнэлэх зөвлөмж өгөв.

2. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд төсөвт батлагдсан орлого 16,0 хувиар тасарч, зардлыг 5,4 хувиар хэтрүүлэн алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг болон санхүүгийн аудитын "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөвт багтаан үр ашигтай ажиллах, зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ гарсан.	1	10,685.3			1	10,685.3		
Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг дутуу тооцоолсон.	1	104,707.3					1	104,707.3
Өглөг нэмэгдсэн.	1	31,697.2			1	31,697.2		
Орлого 16 хувиар тасарч, зардлыг 5.4 хувиар хэтрүүлэн алдагдалтай ажилласан байна.	1	17,561.8					1	17,561.8
Дүн	4	164,651.6			2	42,382.5	2	122,269.1